



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

Зам, тээврийн салбарт авилгын индексийг
бууруулах талаар авах арга хэмжээний
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Авилгын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Транспаренси Интернэшнл" олон улсын төрийн бус байгууллагаас гаргасан судалгаагаар "Монгол Улсад авилгын индекс өссөнүндсэн шалтгаан нь төрийн албан хаагчид эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигладаг байдал нэмэгдсэнээс хамаарсан" тухай судалгааны дүн гарсан төдийгүй Авилгатай тэмцэх газраас хийсэн судалгаагаар зам, тээврийн салбарын хэмжээнд авилгын индексийн түвшин өндөр байгааг арилгах, авилгын төсөөллийн индексийг бууруулах зорилгоор "Зам, тээврийн салбарт авилгын индексийг бууруулах талаар авах арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. "Зам, тээврийн салбарт авилгын индексийг бууруулах талаар авах арга хэмжээний төлөвлөгөө"-ний холбогдох заалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг яамны газар, хэлтсийн дарга болон харьяа байгууллагын удирдлагад даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын газар /М.Энхболд/-т үүрэг болгосугай.



ХАЛТАР

**ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ АВИЛГЫН ИНДЕКСИЙГ БУУРУУЛАХ ТАЛГААР
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

/2021-2023/

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2021 оны дугаар тушаалын
хавсралт

АВЧ

Зохихон байгуулж, үйлдвэрлэх байгууллага, албан тушаалтан

Хугацаа

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Зохихон байгуулж, үйлдвэрлэх байгууллага, албан тушаалтан	Хугацаа
Нэг. Зам, тээврийн салбарын хэмжээнд:				
1	Салбарын хэмжээнд авилгын индексийг бууруулахад нөлөөлөх хүчин зүйлийн талгаар судалгаа гаргах	Судалгаа хийгдсэн байна.	ТЗУГ, БТГ, харьяа байгууллага	2021 оны улирал
2.	Авилгын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох талаар судалгаа гаргах	Судалгаа хийгдсэн байна.	ТЗУГ, БТГ, харьяа байгууллага	2021 оны улирал
3.	Авилгад өртөх магадлал бүхий албан тушаалын жагсаалтыг албан хаагчдын дунд судалгаа явуулж тодорхойлон, зөвлөмж зөвлөгөө боловсруулж тухайн албан тушаалтнуудад хүргүүлэх	Зөвлөмж, зөвлөгөө өгсөн байна.	ТЗУГ, БТГ, харьяа байгууллага	2022 оны улирал
4.	Зам, тээврийн салбарын хэмжээнд худалдан авах ажиллагааг бүрэн цахимжуулан, мэдээллийг олон нийтэд ил тод байршуулж байх	Үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.	БТГ, харьяа байгууллага	2022 оны улирал
5.	Зам, тээврийн салбараас олгож буй тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн ажлыг цахим хэлбэрт шилжүүлж, олон нийтэд ил тод байлгаж, мэдээлэл авах боломж бүрдүүлэх	Тусгай зөвшөөрөл, гэрчилгээ ажиглагаа цахим хэлбэрт шилжсэн байна.	БТГ, ТЗУГ, харьяа байгууллага	2022 оны улирал
6.	Call center буюу Зам, тээврийн салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг иргэд, аж ахуй нэгж, олон нийтээс цахим болон бусад бүх хэлбэрээр хүлээн авч шийдвэрлэж байх	Салбарт хэрэгжиж эхэлсэн байна.	БТГ-ын мэдээлэл технологи, стандартын хэлтэс, ТЗУГ	2021-2023
7.	Зам, тээврийн салбарын албан хаагчдаас иргэдэд үзүүлж буй төрийн үйлчилгээг хэрхэн үзүүлж байгааг үнэлж дүгнэж байх	Салбарт хэрэгжиж эхэлсэн байна.	БТГ-ын мэдээлэл технологи,	2021-2023

			стандартын хэлтэс, ТЗУГ	
8.	Зам, тээврийн салбарын хэмжээнд авилгын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг ЗТХС-ын баталсан сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	Сайдын зөвлөлд танилцуулсан байна.	ТЗУГ, харьяа байгууллага	2021-2023 о
9.	ЗТХД-ны хэмжээнд хэмжээнд авилгын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг ЗТХД-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан тусгай хуваарь, сургалтын төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	Сургалт зохион байгуулсан байна.	ТЗУГ, харьяа байгууллага	2021-2023 о
10.	ЗТХД-ны харьяа байгууллагын ажлыг үнэлэхдээ авилгын индекс бууруулах талаар авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцох	Үнэлгээ хийгдсэн байна.	ХШУДАГ, харьяа байгууллага	2021-2023 о
11.	Авилгын индексийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг Сайдын зөвлөлд жил бүр танилцуулж, үр дүнг үнэлүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулж байх	Сургалт зохион байгуулсан байна.	ХШУДАГ	2021-2023 о
Хоёр. Авто тээврийн салбарт :				
12.	Улс хоорондын байнгын ачаа тээврийн С зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулан, олон нийтэд мэдээллийг ил тод байршуулах	Зөвшөөрлийн үйл ажиллагаа цахимжиж, мэдээлэл ил тод байршсан байна.	Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Автотээврийн үндэсн ийтөв ТӨҮГ	2022 оны улирал
13.	Автотээврийн хэрэгслийн дугаар олгох болон дуудлага худалдааны үйл ажиллагааг бүрэн цахимжуулан, мэдээллийг олон нийтэд ил тод байршуулж, олон нийтийн оролцоог хангах	Улсын дугаар олгох ажиллагаа нээлттэй болсон байна.	Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Автотээврийн үндэсн ийтөв ТӨҮГ	2022 оны улирал
14.	Төлбөр хураах цэгүүд тээврийн хэрэгслийн даац хэтэрсэн эсэхэд хэмжилт хийж, дүүгийн хэмжилтийг цахим хэлбэрээр мэдээллийн санд оруулдаг байх	Мэдээлэл ил тод байршсан байх	Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Автотээврийн үндэсн ийтөв ТӨҮГ	2022 оны улирал

Гурав. Авто замын салбарт:

15.	Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх зэрэг ажлын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулан, олон нийтэд мэдээллийг ил тод байршуулах	Байгууллагын цахим хуудсанд байршуулж санал авсан байна.	Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Зам, тээврийн хөгжлийн төв	2021 оны улирал
16.	Ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан компаний гүйцэтгэх ажил, хугацаа, чанарын талаарх мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлж байх	Компанийн мэдээллийг байршуулсан байна.	Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Зам, тээврийн хөгжлийн төв	2021 оны улирал
17.	Төлбөр хураах цэгийг үйл ажиллагааг цахимжуулан, мэдээллийг ил тод байршуулах	Мэдээлэл ил тод байршуулах	Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Зам, тээврийн хөгжлийн төв	2022 оны улирал
18.	Авто зам, замын байгууламжийг Улсын комисс ажил хүлээн авах ажлын актыг олон нийтэд ил тод мэдээлж байх	Улсын комиссын актыг хугацаанд гаргасан байна.	Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Зам, тээврийн хөгжлийн төв	2022 оны улирал
Дөрөв. Төмөр зам, Далайн тээврийн салбарт				
19.	Төмөр замын ачаа тээвэрлэлтийн талаарх мэдээллийг нээлттэй ил тод болгох	Мэдээлэл боломж бүрдсэн байна.	ТЗДТБХЗГ, "Улаанбаатар төмөр зам" ХНН "Монголын төмөр зам" ТӨХК	2022 оны улирал
20.	Тээвэр зуучийн гэрчилгээ олгох үйл ажиллагааг цахимжуулж, олон нийтийн оролцоог хангаж, мэдээллийг ил тод байршуулах	Мэдээлэл авах болон хяналт тавих нөхцөл бүрдсэн байна.	ТЗДТБХЗГ	2022 оны улирал
21.	Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох ажлыг цахимжуулан, мэдээллийг ил тод байршуулах	Мэдээлэл авах болон хяналт тавих нөхцөл	Далайн захиргаа	2022 оны улирал

22.	Вагоны захиалгыг нээлттэй, цахимаар авч хуваарилалтыг хийж, ил тод байршуулах	Бүрдсэн байна.	Мэдээлэл авах болон хяналт тавих нөхцөл бүрдсэн байна.	ТЭДТЕХЭГ, "Улаанбаатар төмөр зам" ХНН	2022 онь улирал
Тав. Иргэний нисэхийн салбарт					
23.	Тийз олголтын үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, иргэд мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх	Мэдээлэл боломж байна.	авах бүрдсэн	Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ИНЕГ, МИАТ	2021 онь улирал
24.	Нислэгийн чиглэл тогтоох үйл ажиллагаанд агаарын тээвэрлэгч компанийг тэгш эрхтэйгээр оролцуулах боломж бүрдүүлж ил тод мэдээлэх	Нислэгийн тогтооход компаниуд эрхтэй байна.	Чиглэл авиа тэгш оролцсон	Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ИНЕГ, МИАТ	2021-2023
25.	Иргэний нисэхийн салбарт зарласан тендер, худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод болгох	Мэдээлэл боломж байна.	авах бүрдсэн	Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, ИНЕГ, МИАТ	2021-2023